



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: [contact@ub-procurement.mn](mailto:contact@ub-procurement.mn)  
Цахим хаяг: [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)

2024.04.09 № 03/539

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЭМЯ/20240101007/01/01 дугаартай Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвийн барилга 80 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг) ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулгаар тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн байна.

Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.” гэж заасны дагуу ажлын тоо хэмжээ, шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулан зарласан тул эрх байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлаж буй шийдвэр ирүүлснээс бусад тохиолдол тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдийн хүсэлтийн дагуу тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах боломжгүй болохыг үүгээр мэдэгдье.